



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 9/161

Арвайхээр сум

Г Зарим арга хэмжээг хэрэгжүүлэх тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтыг тус тус үндэслэн, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас бусад эх үүсвэрээс болон өөрийн төсвийн хөрөнгөөр эм, эмнэлгийн хэрэгслэл, тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааг өөрийн байгууллага дээрээ хуулийн дагуу зохион байгуулж байхыг сүм, өрхийн эрүүл мэндийн байгууллагын удирдлагуудад даалгасугай.

2.Худалдан авалтын чиглэлээр Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах, эрүүл мэндийн байгууллагуудыг эмийн мэргэжилтэнтэй болоход мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн худалдан авалт, төндөрт шалгарсан байгууллагын гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0290

D:My Doc. Zahiramj. Zasag darga